



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/03

Арвайхээр

Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Хархорин, Өлзийт, Баян-Өндөр, Хайрхандулаан зэрэг сумдад гарсан мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний голомтын халдварлалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, малчдад шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг тасралтгүй хүргэх, сумын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, өвчлөлтэй холбоотой мэдээллийг аймгийн Онцгой комиссын шуурхай штабт өдөр бүр ирүүлж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа)-д даалгасугай.

2.Өвчний голомт бүхий нутагт өвөлжиж хаваржихаар очсон отрын малчдын судалгааг нарийвчлан гаргаж, отрын гэрээний хугацаа дуустал нүүж ирүүлэхгүй байх арга хэмжээг тухайн аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын удирдлагуудтай тохирч, хяналт тавихыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир), Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний голомттой бүс нутгаас зорчиж буй мал, амьтан, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчин илэрч байгаатай холбогдуулан хурдан морь, тэмээний уралдаан, бооцоотой уургач, бугуйлчдын тэмцээн зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг аймгийн Онцгой комиссын зөвшөөрөлгүйгээр зохион байгуулахгүй байхыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Шүлхий өвчний голомт, сэжиг илэрсэн тухай бүр хязгаарлалтын дэглэм, пост эргүүл хяналт шуурхай гаргаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0005

D:My Doc. Zahiramj. Zasag darga